



**ГОВЬСУМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 1130

Шивээговь сум

**Газар эзэмшүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухайн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 31 дүгээр зүйлийн 31.1, 31.2, 31.3, 33 дугаар зүйлийн 33.1.1, Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 136 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Улсын хэмжээнд 2024 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай”, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 04 дүгээр “Төлөвлөгөө батлах тухай” тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ НЬ:**

1. Мэдээлэл холбооны сүлжээ Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Дорноговь аймаг дахь салбар (5081092) нь сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах холбоо, мэдээлэл дамжуулах шугамыг баталгаажуулах хүсэлт гаргасан тул хавсралтад заагдсан газруудыг 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Хуулийн дагуу эзэмшиж буй газрынхаа орчны тохижилтыг сайжруулж, зүй зохицой эзэмшиж, газар эзэмших гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Мэдээлэл холбооны сүлжээ Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Дорноговь аймаг дахь салбарын дарга (М.Нарангэрэл)-д үүрэг болгосугай.

3. Мэдээлэл холбооны сүлжээ Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Дорноговь аймаг дахь салбарт эзэмшил газрын кадастрын ажил гүйцэтгүүлэх хуудсыг өгч, газар эзэмших гэрээ болон гэрчилгээг цахимаар үүсгэж, газрын улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулахыг сумын Газрын даамал (Т.Өлзийбуд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА



Сумын Засаг даргын 2024 оны  
...10... сарын ...29...-ны өдрийн ...11:30  
дугаар захирамжийн хавсралт

### ШИЛЭН КАБЕЛИЙН ЗОРИУЛАЛТААР ЭЗЭМШИЖ БУЙ ГАЗРЫН БАЙРШИЛ

Д/Д	Багийн дугаар	Газар эзэмшигчийн нэр	Регистрийн дугаар	Газрын зориулалт	Газрын хэмжээ /м2/	Газрын байршил
1	2	Мэдээлэл холбооны сүлжээ Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Дорноговь аймаг дахь салбар	5081092	Холбоо мэдээлэл дамжуулах шугам	10238	Засмал замын зүүн талд
2					986	Засмал замын баруун талд
3					35513	Засмал замын баруун талд
4					26240	Шивээ-Овоо уурхайн хойд талд
5					6007	Төмөр замын баруун талд
					78984	